**Батлав:**

_________________________/Г.Энхмөнх/

БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчин бодлогын хэрэгжилтийн газрын дарга

**Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:**

_________________________/Ж.Алтанчимэг/

"Торгон шир бэлтгэл" ХХК-ийн гүйцэтгэх захирал

# УЛААНБААТАР ХОТ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 32-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ МАЛЫН АРЬС НЭХИЙНЭЭС ҮСИЙГ ГЭМТЭЭЛГҮЙГЭЭР ХУУРАЙ ТЕХНОЛОГИЙН АРГААР САЛГАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6675522/

**Хянасан:**

ХБОБЗГ-ын ахлах шинжээч ___________________________ /_____________________ /

**Биелэлтийг тайлагнасан:** "Торгон шир бэлтгэл" ХХК-ийн

байгаль орчны мэргэжилтэн_____________________________ /С.Долгорсүрэн/

2024 он

## Агуулга


1 МАЛЫН АРЬС, НЭХИЙНЭЭС ҮСИЙГ ГЭМТЭЭЛГҮЙГЭЭР ХУУРАЙ ТЕХНОЛОГИЙН АРГААР САЛГАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН .......... 3
1.1 Төслийн товч танилцуулга .......... 3
1.2 Үйлдвэрийн хүчин чадал, техник технологи .......... 4
1.3 Үйлдвэрийн талбай, барилга байгууламж .......... 7
1.4 Химийн бодисын нэр төрөл, зарцуулалт .......... 10
1.5 Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж .......... 10
1.6 Усан хангамж .......... 11
2 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал .......... 14
3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 14
3.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт 14
3.2 Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .......... 15
3.3 Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .......... 15
3.4 Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .......... 16
3.5 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .......... 16
3.6 Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .......... 17
4 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн биелэлт .......... 17
5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 18
5.1 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .......... 18
6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .......... 21
7 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .......... 23
7.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ .......... 23
7.2 Газрын доорх усны хяналт шинжилгээ .......... 24
7.3 Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ .......... 25
7.3.1 Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн .......... 25
8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт .......... 26


Хүснэгтийн жагсаалт:


Хүснэгт 1: Үйлдвэрийн хүчин чадал .......... 5
Хүснэгт 2: Химийн материалын тооцоо, жилээр .......... 5
Хүснэгт 3: Малын арьс нэхийнээс үсийг хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт ашиглах химийн бодисын нэр, төрөл, жилд ашиглагдах хэмжээ .......... 10
Хүснэгт 4: Хатуу хог хаягдлын тооцоо .......... 12
Хүснэгт 5. 2024 оны БОМТ-ний нийт зардлын хэмжээ .......... 14
Хүснэгт 6. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 14
Хүснэгт 7. Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 15
Хүснэгт 8. Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 15
Хүснэгт 9. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 16
Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 16
Хүснэгт 11. Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......... 17
Хүснэгт 12. 2024 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .......... 17
Хүснэгт 13. 2024 оны осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .......... 19
Хүснэгт 14. Агаарын чанарын хяналт шинжилгээ .......... 23
Хүснэгт 15. Агаарын чанарын хэмжилтийн үр дүн .......... 24
Хүснэгт 16. Газрын доорх усны хяналт шинжилгээ .......... 24
Хүснэгт 17. Усны бүрэн шинжилгээний үр дүн .......... 24

Хүснэгт 18. Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ ........ 25
Хүснэгт 19. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн ........ 25
Хүснэгт 20. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө ........ 27

Зургийн жагсаалт:

Зураг 1: Үйлдвэрийн байрны харагдах байдал ........ 7
Зураг 2: Оффисын өрөөнүүдийн дотоод зохион байгуулалт ........ 8
Зураг 3: Ариун цэврийн өрөөний зохион байгуулалт ........ 8
Зураг 4: Ажилчдын хувцас солих, амрах өрөөний зохион байгуулалт ........ 9
Зураг 5: Үйлдвэрийн байрны дотоод зохион байгуулалт ........ 9
Зураг 6: Намаз /Уусмал/ бэлтгэх хэсэг ........ 10
Зураг 7: Самрын яс түлдэг бага оврын халаалтын зуухны зохион байгуулалт ........ 11
Зураг 8: Хог түр хадгалах бункерийн байршил ........ 12
Зураг 9: Үйлдвэрийн ажилчдын хэрэгцээнээс гарах бохир хуримтлуулах цооног ........ 13
Зураг 10. Орчны тохижилтын хүрээнд 2024 онд үйлдвэрийн хашаанд тарьсан суулгацын ургалтын байдал ........ 18
Зураг 11. Үйлдвэрийн байранд галын аюул, осол эрсдэлээс сэргийлсэн самбар, тэмдэг байршуулсан байдал ........ 20
Зураг 12. Үйлдвэрийн байранд галын хорууд байрлуулсан байдал ........ 20
Зураг 13. 2024 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ........ 21
Зураг 14. Үйлдвэрийн талбайд байрлах хогийн цэг ........ 22
Зураг 15. Хөрсний дээж авсан байдал ........ 26

Хавсралт материалын жагсаалт:

Хавсралт материал 1: Хавсралт зургууд
Хавсралт материал 2: Ус, хөрсний лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийн хуулбар
Хавсралт материал 3: Хатуу хог хаягдал тээвэрлүүлэх гэрээний хуулбар, төлбөр төлсөн баримтууд
Хавсралт материал 4: Бохир ус тээвэрлэлтийн гэрээний хуулбар, төлбөр төлсөн баримтууд
Хавсралт материал 5: Аюултай хог хаягдал тээвэрлүүлэх гэрээ, төлбөр төлсөн баримтууд

# 1 МАЛЫН АРЬС, НЭХИЙНЭЭС ҮСИЙГ ГЭМТЭЭЛГҮЙГЭЭР ХУУРАЙ ТЕХНОЛОГИЙН АРГААР САЛГАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

## 1.1 Төслийн товч танилцуулга

| | |
|---|---|
| **Төсөл хэрэгжүүлэгч:** | "Торгон шир бэлтгэл" ХХК |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9011825574 |
| **Регистрийн дугаар:** | 6675522 |
| **Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, 413а тоот. Утас: 88810054 |
| **Төслийн нэр:** | "Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр" |
| **Төслийн зорилго:** | Инновацийн хуурай технологийн аргыг үйлдвэрүүдэд нэвтрүүлснээр богино хугацаанд огт гэмтэлгүй, хэвийн үргэлж ноосыг гаргаж авах ба арьсыг нь дахин боловсруулалтад ашиглах бүрэн боломжтой болох юм. Ингэснээр жил бүр хаягддаг 13.7 сая арьс болон 12 000 тн ноосыг эдийн засгийн эргэлтэд оруулна. |
| **Төслийн талбайн байршил:** | Малын арьс, арьс нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн 8615 м2 газарт байрлана |
| **Талбайн хэмжээ:** | 8615 $м^2$ |




*Зураг 1: Үйлдвэрийн талбайн байршил*




*Зураг 2: Төслийн талбайн байршлын агаар сансрын зураг*

## 1.2 Үйлдвэрийн хүчин чадал, техник технологи

### Үйлдвэрийн хүчин чадал

Үйлдвэр нь өдөрт 4000 ширхэг богийн арьсны үсийг гэмтээлгүйгээр салган авч захиалагчийн шаардлагыг хангаж ажиллана. Үйлдвэр нь 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 05 дугаар сарын 30-ний өдөр дуустал календарийн 7 сарын хугацаанд ажлын 154 хоног ажиллана.

Арьс ширэн түүхий эд нь улирлын чанартай бэлтгэгддэг учир 06-10 саруудад үйлдвэр ажиллахгүй. Энэ хугацаанд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгаа, шинжилгээ, туршилтын ажлууд хийгдэнэ.

*Хүснэгт 1: Үйлдвэрийн хүчин чадал*

| Түүхий эд | Хоногийн хүч чадал, ш | Жилд ажиллах хоног | Жилийн хүч чадал, мян.ш | Бүтээгдэхүүн, тн | Ажиллагсдын тоо, хүн |
|---|---|---|---|---|---|
| Богийн арьс | 4000 | 154 | 616 | 2146 | 44 |

### Үйлдвэрийн технологи

Захиалагчаас нийлүүлсэн арьсыг тоолж үйлдвэрлэлд шууд хүлээн авах ба үсийг сулруулах зориулалттай, урьдчилан бэлтгэсэн уусмалаар шар махан талаас нь шүршээд шүршсэн талаар нь нийлүүлж хавсран 4 цаг орчим хэвтүүлэх ба суларсан үс, ноосыг үслэх машинаар эсвэл гар аргаар салгаж авна.

Энэхүү үс салгах хуурай, технологи нь олон улсад ялангуяа Австрали улсад өргөн хэрэглэгддэг hair save unhairing-liming болон Америк, Испанид өргөн судлагдсан Enzymatic unhairing технологиудыг компанийн судалгаа, туршилтуудын үндсэн дээр сайжруулж, шинээр гаргаж авсан, үсийг авахад заавал дэвтээх, махлах зэрэг ажиллагаа шаарддаггүй, хуурай арьсан дээр шууд хэрэглэдэг технологи юм.

Арьс ширний үсийг сулруулах уусмал нь нэгдүгээр зэргийн бөсгөсөн шохой, хүхэрт натри ($Na_2S$)-ийн 65%-иас багагүй идэвхтэй болон протезын идэвхт энзим байна.

Энэ аргаар салгаж авсан үс /ноос, ноолуур, хөөвөр, хялгас/-ны химийн болон гистологийн бүтцэд ямар ч гэмтэл, эвдрэл гардаггүй бөгөөд ашигласан уусмал нь байгаль, орчин хүний бие организмд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Өдөрт хонины 3000-4000 ш, жилд 0.62 сая нэхийний ноос авахад хэрэглэх түүхий эд, материалын хэрэгцээг Хүснэгт 2-т харуулав.

*Хүснэгт 2: Химийн материалын тооцоо, жилээр*

| **Дамжлага** | **Химийн материал** | **Орц, %** | **Хэрэгцээ, ТН** |
|---|---|---|---|
| Үс сулруулалт | Хүхэрт натри | 0.6 | 46.2 |
| | Шохой | 1.5 | 115.5 |
| /намаз бэлтгэх/ | Ус | 8.6 | 215.6 |
| | Энзим, бактери | 0.01 | 0.8 |
| **Дүн** | | **10.7** | **377.9** |

**Бүтээгдэхүүний хяналт**

Бүтээгдэхүүний хяналт нь дараах шаттай явагдана. Бүтээгдэхүүн, технологийн хяналтыг ерөнхий технологич зохион байгуулна.

Үйлдвэр нь арьс ширэн түүхий эд бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулж түүхий эдийн нийлүүлэлтийг хангаж ажиллана. Бэлтгэн нийлүүлэлтийн гэрээнд түүхий эдэд болон чанарын хамгаалалтад тавигдах стандартын шаардлагыг заавал тусгаж өгнө.

Түүхий эд бэлтгэгч нь түүхий стандартын шаардлага хангасан түүхий эдийг хүлээн авна. Дулааны улиралд бэлтгэгдсэн түүхий эд нь Чанарын хамгаалалт хийх арга. MNS 0060 : 2001 стандартын шаардлага хангасан байна. Хүйтний улиралд зохих стандартын дагуу хөлдөөж хадгалсан байна. Түүхий эдийг үйлдвэрийн түүхий эдийн мэргэжилтэн, чанар шалгагч эсвэл технологич зохих журмын дагуу, тоолж хүлээж авна.

Түүхий эд бэлтгэлийн чиглэлээр баримтлах стандартууд :

- Түүхий эд бэлтгэл. Боловсруулаагүй арьс шир. Техникийн шаардлага. MNS 0060 : 2013
- Түүхий эд бэлтгэл. Арьс ширэнд чанарын хамгаалалт хийх аргууд. MNS 5094 : 2013
- Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн нэр томьёо, тодорхойлолт. MNS 3121 : 2001

Стандартын дагуу бэлтгэгдсэн арьс ширэн түүхийг эдийн үйлдвэрийн чанар шалгагч шалгаж тоолж хүлээж авах ба MNS 3121 : 2001 стандартын дагуу гэмтлийг тодорхойлж шаардлага хангаагүй түүхий эдийг хаягдал боловсруулах хэсэг руу шилжүүлнэ. Шаардлага хангасан түүхий эдийг технологийн боловсруулалтад шилжүүлнэ.

**Технологийн үйл ажиллагаа - хяналт**

Арьс ширнээс ноос үсийг салгах үйл ажиллагаа нь дараах зургийн дагуу явагдана.




A. Түүхий эд хүлээж авах, бэлтгэх -стандартын дагуу бэлтгэгдсэн түүхий эдийг намазлахад бэлдэн, гэсгээн, хатсан хэсэг байвал чийглэж, шар махан талыг дээш харуулан бэлдэнэ.
B. Үс салгах технологи ажиллагаа-тусгай жорын дагуу бэлдсэн үс сулруулах түрхлэгийг шар махан талаас нь түрхэж, шингэсний дараа зооны шугамын дагуу хавсран хураана. 4-5 цагийн дараа үсийг салгана.
C. Үс ноос, арьсыг дараагийн боловсруулалт руу шилжүүлэх

Технологийн боловсруулалтад ирсэн түүхийн эдийг чанар шалгагч цехийн мастер болон технологичид хүлээлгэн өгсний дараа үс салгах үйл ажиллагаа эхлэнэ. Үс салгах үйл ажиллагаа нь технологи эхлэхээс өмнө дараах байдлыг хангасан байна.Үүнд:

a. Технологийн үйл ажиллагааг технологич удирдан явуулна.

b. Тухайн түүхий эдийг боловсруулах технологийг тодорхойлж, боловсруулж батлуулсан байна- технологийн карт;
c. Технологийн орц нормыг нарийн тооцож, зохих хяналтыг хийсэн байна.
d. Химийн материал, түүхий эдийн нөөц, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах;
e. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;

Технологийн дамжлагын хяналтын үйл ажиллагаа

a. Боловсруулах үйлдвэр нь дотроо технологийн дамжлагын хяналтын хэсэгтэй байна.
b. Дамжлагын явцад технологийн параметрүүдийг хянаж шаардлагатай технологийн шинжилгээг хийнэ.
c. Дамжлагын хяналт нь үйл ажиллагааны журамтай байх, байгууллагын болон MNS стандартын аргачлалын дагуу шинжилгээ хийнэ.
d. Шинжилгээнд хэрэглэгдэх уусмалыг аргачлалын дагуу мэргэжлийн хүн бэлтгэж, засварын факторыг тогтоосон байна.
e. Шинжилгээг чанар шалгагч эсвэл лаборант хийж, технологич хянаж технологийг тохируулна.
f. Дамжлагын лабораторийн хяналтыг "лабораторийн шинжилгээний тэмдэглэл" ийн дагуу хийж баримтжуулна.

**Бэлэн бүтээгдэхүүний хяналт**

Боловсруулах үйлдвэрийн хувьд бүтээгдэхүүнүүд нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

1. Хуурай технологийн аргаар салгасан үс ноос : хонины ноос, үхрийн хөөвөр, ямааны ноолуур, тэмээний ноос
2. Нүцгэн арьс: хуурай технологийн аргаар үс ноосыг нь салгасан арьс, шир, бэлэн бүтээгдэхүүний хяналтад шаардлагатай стандартууд :
   - Арьс шир. Лабораторийн шинжилгээнд хамрагдах дээжийн тоог тодорхойлох. 3272:1990
   - Арьс шир. Талбай хэмжих арга. MNS 2369:2001
   - Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал. Зумласан ноос. Техникийн шаардлага. MNS 5251:2008,
   - Бүх төрлийн ноос, ноолуур, ширхэгт материалыг баглах, хаяглах, хадгалах, тээвэрлэх журам. MNS 215:2001
   - Арьс шир. Желатин, цавуу, малын уурагт тэжээлийн түүхий эд. Техникийн шаардлага MNS 3348:2003.

Эцсийн бүтээгдэхүүний хяналтыг хийхдээ хамтын ажиллагааны хүрээнд итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллана.

## 1.3 Үйлдвэрийн талбай, барилга байгууламж

Үйлдвэрлэлийн байгууламж нь 84 м урт, 16 м өргөн, 9 м өндөртэй, 1635 $м^2$ талбайтай,



*Зураг 3. Үйлдвэрийн байрны харагдах байдал*

Үйлдвэрийн барилга дотор оффис, ажилчдын хоолны газар, ажиллагсдын хувцас солих, амрах өрөө, ариун цэврийн болон бойлерын өрөөнүүдтэй



*Зураг 4: Оффисын өрөөнүүдийн дотоод зохион байгуулалт*



*Зураг 5: Ариун цэврийн өрөөний зохион байгуулалт*



*Зураг 6: Ажилчдын хувцас солих, амрах өрөөний зохион байгуулалт*

Харуул, хамгаалалтын байртай, эдгээр нь үйлдвэрлэлийн барилгын хамт самрын яс түлдэг бага оврын халаалтын зуухаар халаана.

Хатуу хог, хаягдлын цэгтэй, үйлдвэрийн барилгын талбайн 20%-иос багагүй хувь нь ногоон байгууламжтай байхаас гадна шөнийн гэрэлтүүлэгтэй, үйлдвэрийн дотор, гадна орчны камержуулалт, дохиолол, харуул хамгаалалтын системтэй байна.

Усгүй технологиор үйлдвэрлэл явуулах учраас шингэн хаягдал гарахгүй бөгөөд, бохирыг зайлуулах суваг, шуудуу, цэвэрлэх байгууламж шаардагдахгүй.



*Зураг 7: Үйлдвэрийн байрны дотоод зохион байгуулалт*

Үйлдвэрийн барилга нь сэндвичэн бүтээцтэй, дулааныг гадагш алдагдуулахгүй байх технологи ашигласан байна.

## 1.4 Химийн бодисын нэр төрөл, зарцуулалт

Малын арьс нэхийнээс үсийг хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт 3 нэр төрлийн химийн бодис ашиглана (Хүснэгт 3). Үйлдвэрт ашиглах химийн бодисуудыг "Империал партнерс" ХХК-аас нийлүүлнэ.

*Хүснэгт 3: Малын арьс нэхийнээс үсийг хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт ашиглах химийн бодисын нэр, төрөл, жилд ашиглагдах хэмжээ*

| № | Монгол нэр | Олон улсын нэр | Томьёо | CAS дугаар | Хэмжээ, тн (1 жилд) | Үүнээс ашигласан тн (10.31) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бөсгөсөн шохой | Hydrate lime | $Ca(OH)_2$ | 1305-62-0 | 115 | 85 |
| 2 | Хүхэрт натри | Sodium sulfide | Na2S | 1313-82-2 | 43 | 35 |
| 3 | Энзим бактери | EVICON-CNS, Antibacterial, Antifungal and other VOCS removers | - | Хольц | 0.8 | 0.6 |
| | | **Нийт дүн** | | | **159** | **121** |



*Зураг 8: Намаз /Уусмал/ бэлтгэх хэсэг*

## 1.5 Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбайд 6кв/0.4кв-ын цахилгааны дэд станцтай бөгөөд мэргэжлийн байгууллагаар зураг төсвийн дагуу монтаж хийлгэхээр төлөвлөсөн. Үйлдвэрийн ТЭЗҮ-д тооцоолсноор жилд дунджаар 12,320 кВт цахилгаан зарцуулна.

Төлөвлөж буй үйлдвэр нь уурын зуухаар үйлдвэрийн барилга байгууламжийг халаана. 11 дүгээр сараас 5 дугаар сар хүртэл галлахаар төлөвлөсөн.





*Зураг 9: Самрын яс түлдэг бага оврын халаалтын зуухны зохион байгуулалт*

## 1.6 Усан хангамж

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны хэрэглээг ("Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан **"Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"**-ын 14 дугаар хавсралт "Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм"-д зааснаар албан байгууллага /захиргааны барилга/ 1 ажилтны хоногийн дундаж усны хэрэглээ) **80 литрээр** тооцлоо. Бүрэн хүчин чадлаараа хамгийн ихдээ 44 хүн ажиллана гэж үзэн, төслийн ажиллах хугацаа /жилийн 11-5 сарын хугацаанд 154 хоног/-нд:

- Ажилчид 44 хүн * 80 л = 3520 л буюу 3.5 $м^3$/хон
  Жилд 154 хоногт * 3.5 $м^3$/хон = 542.1 $м^3$/жил,

Үйлдвэрийн талбайд нийт 30 ш суулгац тарих ба 13 дугаар хавсралт "Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм"-д зааснаар 1 ш суулгац услахад **40 литр** ус зарцуулна /жилийн 5-10 сарын хугацаанд 6 удаа/-нд:

- 30 ш суулгац х 40 л ус х 6 удаа = 7.2 $м^3$/ус

Үйлдвэрийн технологид 1 ш арьсанд 0.35 л ус. Хоногт 4000 ш арьсанд 1400 л, жилд (154 хоног) 215.6 ус орно.

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардагдах нийт усны хэмжээ жилд 764.9 $м^3$.

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбайд 120 м гүн өрмийн худаг байрлах усны тогтоосон түвшин 18 метр, цоногийн ашиглалтын усны ундарга 84 метр, шүүрийг 40-120 метрийн гүнд суурилуулсан байна. Төслийн талбайн гүний худгийн байршлыг доорх зурагт үзүүлэв.

**Хог хаягдал**

Хог хаягдлыг ерөнхийд нь аливаа үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээнд шууд нийцэхгүй болсон материал гэж тодорхойлдог (OECD, 2003). Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад дор дурдсан гарал үүсэлтэй хог хаягдал гарна. Үүнд:

- Ахуйн гаралтай хаягдал

- Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал

## Ахуйн гаралтай хог хаягдал

*Хатуу хог хаягдал*

Ахуйн гаралтай хог хаягдалд үйлдвэрийн ажилчдын хэрэглээнээс гарах хоолны үлдэгдэл, цэнэг хураагуур, хаягдал цаас, хайрцаг, шилэн сав, лонх, хуванцар сав, хуванцар эдлэл, даавуун болон нийлэг эдлэл гэх мэт хаягдлууд орно.

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт 44 хүн ажиллана.

*Хүснэгт 4: Хатуу хог хаягдлын тооцоо*

| Нийт ажиллах хоног/жилд хоног, | Ахуйн хог хаягдал, кг | Нийт хүний тоо | Нийт, кг/жил |
|---|---|---|---|
| **154** | 0.5 | 44 | 3388 кг |

Дээрх хүснэгтээс харахад үйлдвэрийн ажилчдаас жилд ойролцоогоор 3.4 ахуйн хог хаягдал гарахаар байна.

Ахуйн хог хаягдлыг Сонгинохайрхан дүүрэгтэй хог ачилт, тээвэрлэлтийн гэрээ хийн тогтмол хугацаанд ачуулах ба тухайн газрын зөвлөсөн хогны бункерийг хашаандаа байрлуулсан.



*Зураг 10: Хог түр хадгалах бункерийн байршил*

Үс, ноос салгаж авсан арьсаа цаашид арьс, шир боловсруулах үйлдвэр, цавууны үйлдвэр, муур, нохойны хоолны үйлдвэр зэрэг үйлдвэрүүдэд нийлүүлэхээр төлөвлөж байна. Иймээс үйлдвэрийн хог хаягдал гарахгүй.

*Шингэн хог хаягдал*

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн ажилчдын ахуйн шингэн хаягдал, ажилчдын гал тогооноос үүсэх ахуйн бохир ус зэрэг шингэн хаягдлууд үүснэ.

Ажилчид унд ахуйн хэрэгцээнд хоногт нийт 3.5 $м^3$ ус хэрэглэнэ. Үүнээс 100%-ийг хаягдал ус гэж үзвэл: Жилд 3.5 $м^3$/хоног * 154 хоног = 539 $м^3$/жил болно.

Үйлдвэр нь ахуйн хэрэгцээнээс гарах бохирыг өөрийн урсгалаар гаднах 50 тн 2 ширхэг бохир хуримтлуулах ёмскт хуримтлуулна.



*Зураг 11: Үйлдвэрийн ажилчдын хэрэгцээнээс гарах бохир хуримтлуулах цооног*

**Химийн бодисын сав, баглаа боодлын хаягдал**

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх химийн бодисын сав баглаа боодол болон хэрэглэгчдээс дахин ашиглах боломжтой савыг эргүүлэн авч химийн бодисын хог хаягдлыг устгах, боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий "Элемент" ХХК-д нийлүүлнэ.

## 2 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

2024 оны БОМТ-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйлдвэрийн барилгажилтын явцад байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, хог хаягдлын менежмент, орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийсэн. 2024 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 7,158,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

*Хүснэгт 5. 2024 оны БОМТ-ний нийт зардлын хэмжээ*

| # | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зардал, төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 620,000 |
| 2 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 1,800,000 |
| 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 0 |
| 4 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1,728,000 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 900,000 |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 1,510,000 |
| 6 | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө | 600,000 |
| **Нийт зардал** | | **7,158,000** |

## 3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах болон нөхөн сэргээлт хийсэн ажлуудын биелэлтийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр дараах дэд бүлгүүдээр дэлгэрүүлэн тусгав.

### 3.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

*Хүснэгт 6. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Газрын гадарга, хэвлий** | | | |
| Барилгын ажил болон ашиглалтын явцад ашиглагдах машин, техник тоног төхөөрөмжөөс ШТМ алдагдаж, газрын гадаргыг бохирдуулж болзошгүй | Түүхий эд тээвэрлэх тээврийн хэрэгслүүдийг тусгайлан бэлтгэсэн зогсоолд зогсоох, тээврийн хэрэгслүүдийн шатах тослох материал асгарч болзошгүй эд ангиудад үзлэг, асгарсан тохиолдолд хязгаарлах, цэвэрлэх | Үйлдвэрийн талбайд | Түүхий эд тээвэрлэх тээврийн хэрэгслүүдийг тусгайлан бэлтгэсэн зогсоолд зогсоож, тээврийн хэрэгслүүдийн шатах тослох материал асгарч болзошгүй эд ангиудад тогтмол хугацаанд үзлэг хийв. |
| Химийн хортой, аюултай химийн бодис хадгалах явцад алдагдаж орчны газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй | Химийн бодисын асгаралт, алдагдал үүссэн тохиолдолд асгаралтыг холбогдох хэлтсүүдэд мэдээлэх, шингээх, саармагжуулах арга хэмжээг нэн тэргүүнд авах | Химийн бодисын агуулах | Химийн бодисын агуулахын стандартад нийцүүлж тохижуулав. |

## 3.2 Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

*Хүснэгт 7. Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Агаарын чанар** | | | |
| Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслүүдээс нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бага хэмжээгээр нэмэгдүүлнэ | Тээврийн хэрэгсэл сонгон ашиглахдаа тухайн хэрэгслийн үр ашигтай байдал болон түлшний зарцуулалтыг харгалзан үзнэ | Үйлдвэрийн тээврийн хэрэгслүүд | Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашгилдаг тээврийн хэрэгслүүдэд чанар сайтай шатах, тослох материал ашгилдаг. Тогтмол хугацаанд үзлэг оношилгоонд оруулж, засвар үйлчилгээг хийлгэдэг. |

## 3.3 Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

*Хүснэгт 8. Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Агаарын чанар** | | | |
| Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагаа доголдож болзошгүй бөгөөд үүнээс үүдэн дотоод орчны агаарын чанар муудах, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй | Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ-нээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг ханаж, стандартад заасан хэмжээнд байлгана. | Үйлдвэрийн дотоод орчин | Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ-нээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг ханаж, стандартад заасан хэмжээнд байлгах зорилгоор үйлдвэрийн дотоод орчинд мэргэжлийн байгууллагаар агаарын чанарын хэмжилт хийлгэсэн (ОХШХ-д тусгасан). |
| Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгслүүдээс нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч, агаарын чанарын найрлагад түр хугацаанд, бага хэмжээгээр нөлөөлнө | Тээврийн хэрэгслүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал утааны шүүлтүүр ашиглах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ | Тээврийн хэрэгслүүд | Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашгилдаг тээврийн хэрэгслүүдэд чанар сайтай шатах, тослох материал ашгилдаг. Тогтмол хугацаанд үзлэг оношилгоонд оруулж, засвар үйлчилгээг хийлгэдэг. |

*Тээврийн хэрэгслийн үзлэг:* Тээврийн хэрэгслүүд жил бүр тээврийн хэрэгслийн улсын үзлэгт хамрагддаг.

## 3.4 Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

*Хүснэгт 9. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Гадаргын ба газрын доорх ус** | | | |
| Барилгажилт болон ашиглалтын үед үүсэх хатуу, хаягдал, хур тунадас орсон үед үерийн усаар дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй | Барилгажилт болон ашиглалтын үед үүсэх хог хаягдлыг цуглуулж, хог гэрээлэгч байгууллагаар тогтмол хугацаанд ачуулна. | Өрөмдлөгийн худаг | Барилгажилт болон ашиглалтын үед үүсэх хог хаягдлыг цуглуулж, хог гэрээлэгч байгууллагаар тогтмол хугацаанд ачуулдаг |
| | Үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах худгийн ус авах шугамд тоолуур суурилуулна. | Худаг | Үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах худгийн ус авах шугамд тоолуур суурилуулсан. |

## 3.5 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

*Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Хөрсөн бүрхэвч** | | | |
| Тээврийн хэрэгслүүдээс ШТМ, химийн бодисын үлдэгдэлтэй савнаас химийн бодис алдагдсан тохиолдолд орчны хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй | Химийн бодис шилжүүлэн ачих, тээвэрлэх, хадгалах явцад ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллана. | Химийн бодис тээвэрлэх, шилжүүлэн ачих, хадгалахад оролцож буй бүх ажилчид | Химийн бодис шилжүүлэн ачих, тээвэрлэх, хадгалах явцад ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг ажилчдад танилцуулж, шаардлага тавьж ажиллав. |

## 3.6 Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

*Хүснэгт 11. Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Ургамлан нөмрөг** | | | |
| Үйлдвэрийн талбай нь өмнө хөндөгдсөн, байгалийн ургамалжилтгүй талбайд баригдах тул ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй. Харин орчны тохижуулалтаар тарсан мод, сөөг нөлөөлөлд өртөж болзошгүй | Орчны тохижуулалтын хүрээнд тарьсан мод, сөөгийг арчилж тордох | Үйлдвэрийн талбайн хойд хэсэгт ойролцоогоор 150 $м^2$ талбайд тарьсан мод, сөөгүүд | Үйлдвэрийн талбайд шинээр 150 $м^2$ талбайд тухайн орчинд тохирсон мод тарьж, арчилж тордсон |

## 4 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн биелэлт

Үйлдвэрийн талбайн хойд хэсэгт орчны тохижуулалтын хүрээнд нутгийн унаган мод, сөөгийг ойролцоогоор 150 $м^2$ талбайд тарьж ургуулсан. Эдгээр мод сөөгүүдийг арчилж, тордохын зэрэгцээ. Мөн ногоон байгууламжийн талбайг 150 $м^2$-аар нэмэгдүүлсэн. (Үйлдвэрийн талбайд тэр бум модны хүрээнд 50 ширхэг мод тарьсан)

*Хүснэгт 12. 2024 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*

| # | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Тоо хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Орчны тохижуулалт | Мод, сөөгийг тарьж ургуулах, арчилж, тордох, (*тэр бум модны хүрээнд 50 ширхэг мод тарина)* | 150 м2 | 2024 онд 1 удаа | Үйлдвэрийн талбайн шинээр 150 $м^2$ талбайд 50 ш мод сөөг тарих болон хойд хэсэгт тарьсан мод, сөөгийг арчилж тордсон |

Тайлант хугацаанд үйлдвэрийн 150 $м^2$ талбайд тарьц суулгацыг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу услах, арчилж тордох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. 2024 оны байдлаар тарьсан бургасны ургалт 90 хувьтай байна (Зураг 12).



*Зураг 12. Орчны тохижилтын хүрээнд 2024 онд үйлдвэрийн хашаанд тарьсан суулгацын ургалтын байдал*

## 5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2024 оны төслийн барилгын ажлын явцад хөрсөнд хадгалагдсан палеонтологи болон археологийн олдвор илрээгүй.

### 5.1 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Төслийн бүхий л үе шатанд тохиолдож болзошгүй осол, аюул, эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгав.

Осол, аюулыг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилав. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад үүсэх осол,
- Мэргэжлээс шалтгаалах өвчлөл, халдварт өвчин тархалтаас шалтгаалсан осол,
- Аюултай бодис асгарах,
- Байгалийн гамшиг тохиолдох,
- Гал түймэр гарах,
- Хяналтаас гадуурх дэлбэрэлт үүсэх,
- Хаягдал хадгалах байгууламжийн далан нурах, хаягдлын зуурмагийн дамжлага эвдрэх,
- Тээврийн хэрэгслийн осол гарах.

**Баримтлах эрх зүйн баримт бичиг**

Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй химийн хорт болон аюултай бодистой холбоотой хууль тогтоомжуудыг биелүүлэх нь хүний эрүүл мэнд байгаль орчин, төслийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Химийн хорт болон аюултай бодистой холбоотой дараах хууль журмуудыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллана.

- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль,
- Эрүүгийн хууль,
- Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/,
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/,
- Гамшгаас хамгаалах тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,

- Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай,
- Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт, Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт,
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам, БОАЖСайд, ГХСайдын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 334/104 дүгээр хамтарсан тушаал,
- MNS 6458: 2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага,
- MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг,
- MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. ААН, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм,
- MNS 12.104-94 Хөдөлмөр хамгааллын стандартын систем,
- MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага,

*Хүснэгт 13. 2024 оны осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

| # | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Аюултай бодис асгарах | Үйлдвэр ашиглах химийн бодисуудыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, ашиглах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулна | Химийн бодисын агуулах | Химийн бодисын агуулахыг химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам болон стандартад нийцүүлж тохижуулав. |
| 2 | Гал түймэр | 1. Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авах<br>2. Дараах эрсдэл бууруулах арга хэмжээг авах:<br>-Гал түймэртэй тэмцэх хэсгийг гал унтраах мэргэжлийн сургалтад хамруулах,<br>-Тогтмол гал түймэртэй тэмцэх дасгал сургууль зохион байгуулах,<br>-Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах,<br>-Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын (хэрэв тодорхой биш бол, жишээ нь ганц хаалгатай бол) байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуул, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх хэрэгтэй.<br>3. Гал гарсан тохиолдолд:<br>-Галаас яаралтай гарах<br>-Химийн бодис, тэсрэх бодистой ажиллахад тэдний хадгалах бүх зааврыг хатуу дагаж мөрдөх, тэдгээр бодисыг зохих газарт нь хадгалах | Төслийн бүх байгууламжуудад | Үйлдвэрийн байранд галын дохиолол, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулсан; галын дохиолол, гал унтраагуул, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг байршуулсан.<br>Осол эрсдэлээс хамгаалсан тэмдэг байршуулсан<br><br>Үйлдвэрийн байранд галын дохиолол, талбайд галын хоруудыг зохих газруудад байрлуулсан. |

| # | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|---|
| | | -Гал түймрийн үед барилга байгууламж бүрт тохирох зааврыг ашиглах | | |
| 3 | Хүний эрүүл мэнд муудах | Хүний эрүүл мэнд муудахад Компанийн эрүүл мэндийн ажилтнууд дүгнэлт гаргаж, тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой газар руу нүүлгэн шилжүүлэхийг ажлыг зохион байгуулна. | Төслийн бүх байгууламжуудад | 10 дугаар сарын байдлаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлээгүй байна. Хэрэв эхэлсэн тохиолдолд үйлдвэрийн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан ажиллана. |






*Зураг 13. Үйлдвэрийн байранд галын аюул, осол эрсдэлээс сэргийлсэн самбар, тэмдэг байршуулсан байдал*




*Зураг 14. Үйлдвэрийн байранд галын хоруud байрлуулсан байдал*

## 6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэрийн барилгын бол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг түр хадгалах цэгт ангилан, цуглуулдаг бөгөөд Сонгинохайрхан дүүргийн хог хаягдлын менежмент хийдэг тусгай зөвшөөрөлтэй "Эко эрин тохижилт" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлдэг. Ахуйн хэрэглээнээс үүссэн шингэн хаягдлыг 50 $м^3$ багтаамжтай бохирын худаг цуглуулдаг. Цуглуулсан бохир усыг тусгай зөвшөөрөлтэй "Дондовдаш" ХХК-аар бохирын нэгдсэн байгууламж руу тээвэрлүүлдэг *(Хатуу, шингэн хог хаягдал тээвэрлэх гэрээнүүдийн хуулбарыг тайланд хавсаргав)*.

Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хүргэх ажлыг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар менежмент хийхээр төлөвлөсөн. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 14. 2024 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

| Чиглэл | Хог хаягдлын менежментийн арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Биелэлт |
|---|---|---|---|
| **Аюултай хог хаягдал** | Аюултай хог хаягдлыг тусгай цэгт хуримтлуулан, гэрээний дагуу аюултай хог хаягдлын дахин боловсруулах болон устгах зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай гэрээ хийн гэрээний дагуу тогтмол хугацаанд нийлүүлэх нь зүйтэй | Тухай бүр | Химийн бодисын сав баглаа химийн бодисын хог хаягдлыг устгах, боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий "Элемент" ХХК-аар тээвэрлүүлэхээр гэрээний дагуу тээвэрлүүлсэн. |
| **Ахуйн хог хаягдлын менежмент** | Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, Сонгинохайрхан дүүргийн НААҮГ-тай хог тээвэрлэлтийн гэрээ хийн тогтмол хугацаанд ачуулах | Хог хадгалах цэг дүүрсэн тухай бүрд | "Эко эрин тохижилт" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хатуу хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргүүлсэн.<br>"Дондовдаш" ХХК үйлдвэрийн ахуйн бохир усыг зөөвөрлөх менежментийг хариуцан ажиллаж байна<br>*(Гэрээг тайлангийн хавсралтаас үзнэ үү).* |



*Зураг 15. Үйлдвэрийн талбайд байрлах хогийн цэг*

## 7 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2024 оны БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрийн хяналт шинжилгээ, хэмжилт, дээжлэлт авах ажлыг холбогдох стандарт, аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг дараах хэсэгт дэлгэрүүлэн үзүүлэв.

### 7.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Үйлдвэрийн талбай, үйлдвэрийн дотоод орчинд нийт 2 цэгт 2 удаагийн хэмжилтээр агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэсэн.

*Хүснэгт 15. Агаарын чанарын хяналт шинжилгээ*

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Байршил | Хугацаа ба давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ | Биелэлт |
|---|---|---|---|---|
| Орон байрны доторх агаар бохирдуулах бодис, физик нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ<br>-Температур<br>-Агаарын урсгалын хурд<br>-Харьцангуй чийглэг<br>-Нүүрсхүчлийн хий (CO)<br>-Гэрэлтүүлэг | Үйлдвэрийн барилга, талбай | Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | 2 цэгт 2 удаа | Үйлдвэрийн талбай болон үйлдвэрийн талбайд 2 цэгт 2 удаа том, жижиг ширхэглэгт тоосонцор ($PM_{10}$, $PM_{2.5}$), хүхэрлэг хий , дуу шуугиан, харьцангуй чийглэг, гэрлийн тодрол, салхины хурд, температурын хэмжилт хийсэн. |

2024 оны 06 дугаар сарын 17 болон 08 дугаар сарын 10, өдрүүдэд үйлдвэрийн талбайд ажиллах хугацаанд агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлох зорилгоор 2 цэгт хэмжилт хийсэн. Агаарын чанарын Air Quality detector CHD-11 маркийн багажаар агаар дахь том, жижиг ширхэглэгт тоосонцрууд ($PM_{2.5}$, $PM_{10}$)-ын агууламжийг, дуу шуугиан, харьцангуй чийгшил, салхины хурд, гэрлийн тодролын хэмжилтүүдийг MASTECH MS6300 зөөврийн багажаар тус тус хэмжив.



*Үйлдвэрийн гадна*



*Үйлдвэрийн дотор*

*Зураг 16. Агаарын чанарын хэмжилт хийсэн байршил*

Агаарын чанарын хэмжилтийн үеийн мэдээллүүд болон хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 (Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага) стандарттай харьцуулан дараах хүснэгтэд оруулав.

*Хүснэгт 16. Агаарын чанарын хэмжилтийн үр дүн*

| дд | Байршил | Огноо | Агаарын температур, $^{o}C$ | Гэрлийн тодрол, люкс | Харьцангуй чийглэг, % | Салхины чиг, хурд м/с | Дуу шуугиан, дБА | $PM_{2.5}$ | $PM_{10}$ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мкг/м$^3$ | |
| 1 | Үйлдвэр дотор | 2024.06.17 | 30.5 | 69 | 23.2 | - | 40.5 | 1 | 1 |
| | Үйлдвэрийн гадна | 2024.06.17 | 30.0 | - | 21.9 | 2.2 | 48.0 | 1 | 2 |
| 2 | Үйлдвэр дотор | 2024.08.10 | 23.6 | 45 | 63.8 | | 49.5 | 2 | 3 |
| | Үйлдвэрийн гадна | 2024.08.10 | 21.3 | | 65.4 | 0.5 | 48.9 | 7 | 9 |
| **MNS 4585:2016** | | | | | | | **60** | **50** | **100** |

*Агаар дахь тоосонцрын агууламж:* Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүдэд агаар дахь том болон жижиг ширхэглэгт тоосонцрын дундаж агууламж MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага байна.

Дуу шуугианы хэмжилт хийж байх хугацаанд хэмжилтэд нөлөөлдөг хүчин зүйлүүд (салхины хурд, агаарын чийгшил, машины хөдөлгөөн)-ийг тэмдэглэж, бүртгэл хөтөлсөн. Дуу шуугианы хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 (Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага) стандартын өдрийн цаг (07:00-22:00)-ийн утгатай харьцуулав. Дуу шуугианы бүх цэгүүдэд хэмжилтийн утга MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага гарсан.

## 7.2 Газрын доорх усны хяналт шинжилгээ

Ажилчдын унд, ахуйн хэрэглээний усыг баллонтой ус зөөврөөр авч ашигладаг. Угаалга цэвэрлэгээ, үйлдвэрийн хэрэгцээний усыг үйлдвэрийн талбайд байрлах худгаас хангадаг.

*Хүснэгт 17. Газрын доорх усны хяналт шинжилгээ*

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Байршил | Хугацаа ба давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ | Биелэлт |
|---|---|---|---|---|
| Усны чанарын шинжилгээ (Ca, Mg, Cl, $SO_4$, $NO_2$, $NO_3$, $NH_4$, $HCO_3$, Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Cn, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар) | Үйлдвэрийн талбайд байрлах өрөмдлөг худаг | Үйлдвэрийн хэрэгцээний уснаас жилд 1 удаа | 1 цэг | Үйлдвэрийн талбайд байрлах өрөмдлөг худгийн уснаас 1 удаа дээж авч усны ерөнхий үзүүлэлтийг шинжлүүлсэн |

Усны бүрэн (ерөнхий химийн) шинжилгээг Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лабораторид хийлгэсэн. Усны шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 (Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ) стандарттай харьцуулан дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

*Хүснэгт 18. Усны бүрэн шинжилгээний үр дүн*

| # | Үзүүлэлт, нэгж | Өрөмдлөг худаг | MNS 0900:2018 |
|---|---|---|---|
| | | 8-р сар | |
| 1 | $Cl^{-}$, мг/л | **408.3** | **350** |
| 2 | $SO_4^{2-}$, мг/л | 420.0 | **500** |
| 3 | $NO_2^{-}$, мг/л | 0.7 | **1** |
| 4 | $NO_3^{-}$, мг/л | 12.0 | **50** |

| # | Үзүүлэлт, нэгж | Өрөмдлөг худаг 8-р сар | MNS 0900:2018 |
|---|---|---|---|
| 5 | $CO_3^{2-}$, мг/л | 0.0 | **-** |
| 6 | $HCO_3^-$, мг/л | 305.0 | **-** |
| 7 | Нийт анион | 1146.0 | **-** |
| 8 | $Na^+$+ $K^+$ | 210.9 | **-** |
| 9 | $Ca^{2+}$, мг/л | **174.1** | **100** |
| 10 | $Mg^{2+}$, мг/л | **92.4** | **30** |
| 11 | $NH_4^+$, мг/л | 0 | **1.5** |
| 12 | $Fe^{2+}$, мг/л | 0.0 | **-** |
| 13 | $Fe^{3+}$, мг/л | 0 | **-** |
| 14 | Нийт катион | 477.4 | **-** |
| 15 | Нийт ион | 1623.4 | **-** |
| 16 | Хатуулаг, мг-экв/л | **16.29** | **7** |
| 17 | pH | 7.43 | **6.5-8.5** |
| 18 | ЦДЧ, мкСм/см | 1916 | **-** |
| 19 | ПИЧ, мг/л | 2.56 | **-** |
| 20 | TDS, ppm | 1149 | **-** |

Усны бүрэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд худгийн ус химийн бүрэлдэхүүнээрээ хлорын холимог бүлгийн ангийн, 3-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, калци, магни, хлорын ионуудын агууламж нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартад заасан хэмжээнээс их гарсан иймд унданд хэрэглэх тохиромжгүй байна.

## 7.3 Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ

Үйлдвэрийн талбайд 1 цэгээс хөрсний хүнд металлын дээж авч шинжлүүлэхээр төлөвлөсөн.

*Хүснэгт 19. Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ*

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Байршил | Хугацаа ба давтамж | Биелэлт |
|---|---|---|---|
| Хөрсөн дэх хүнд металууд Ag, Al, As, B, Ba, Be, Bi, Ca, Cd, Co, Cr, Cu, Fe, Ga, Hg, K, La, Mg, Mn, Mo, Na, Ni, P, Pb, S, Sb, Sc, Sr, Th, Ti, Tl, U, V,W, Zn | Үйлдвэрийн талбайд 1 цэг | 1 удаа | Үйлдвэрийн талбайд баруун хойд талд 1 цэгээс хөрсний дээж авч шинжлүүлсэн |

Хөрсний хүнд металлын дээжийг “Нарт ШУУН” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

### 7.3.1 Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн

Хөрсний хүнд металлын дээжийн лабораторийн шинжилгээний үр дүнг MNS 5850:2019[1] стандарттай харьцуулан дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 20. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн*

| Элемент | Хэмжих нэгж | Дээж 1 | MNS 5850:2019 | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ЗДХ | Хортой агууламж | Аюултай агууламж |
| Cd | ppm | 0.0 | 3 | 10 | 20 |

[1] MNS 5850:2019 (Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ)

| Элемент | Хэмжих нэгж | Дээж 1 | MNS 5850:2019 | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ЗДХ | Хортой агууламж | Аюултай агууламж |
| Cr | ppm | 66.7 | 150 | 400 | 1500 |
| Cu | ppm | 17.8 | 100 | 500 | 1000 |
| Ni | ppm | 54.7 | 150 | 1000 | 1800 |
| Pb | ppm | 38.6 | 100 | 500 | 1200 |
| Zn | ppm | 54.7 | 300 | 600 | 1000 |

Дээрх лабораторийн шинжилгээний үр дүнгээс харахад хөрсний дээж дэх хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандартад заасан ЗДХ-ээс бага гарсан.






*Зураг 17. Хөрсний дээж авсан байдал*

## 7.4 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт

*Зураг 18.Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Удирдлага, зохион байгуулалт** | | | |
| БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх | Тухайн жилийн БОМТ-г боловсруулж, БОУАӨЯ-аар хянуулж батлуулна. Батлагдсан БОМТ-г хэрэгжүүлнэ. | Үйлдвэр болон үйлдвэрийн талбай | 2024 оны БОМТ-г БОУАӨЯ-аар батлуулсан. |
| Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйлдвэрийн ажилчдыг чадавхжуулах | Ажилчдад олгодог хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит сургалтын хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах чиглэлийн ажлуудыг тайлбарлан таниулна. | Үндсэн болон гэрээт ажилчид | Үндсэн болон гэрээт компанийн ажилчдад Байгаль орчны бодлого, байгаль орчныг хамгаалах журам болон Аюулгүй ажиллагааны хугацаат зааварчилгааны хүрээнд байгаль орчныг хамгаалах, болзошгүй нөлөөллүүдээс сэргийлэх, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын зааварчилгааг улирал тутамд өгсөн. |

## 8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

2024 оны БОХТ-ний биелэлтийн тайланг цахимаар буюу БОУАӨЯ-ны Байгаль орчны мэдээллийн сангийн БОМТ-ний биелэлтийн тайлан (Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан (eic.mn)) хэсэгт холбогдох мэдээллийн хамт оруулж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасан хугацаа (11-р сарын 1-ний дотор)-нд илгээсэн.

*Хүснэгт 21. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө*

| # | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | БОУАӨЯ -ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газарт | “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тайлан бэлтгэж хүргэх | БОХТ-ний хэрэгжилтийг байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрээр гаргасан байх | 2024 онд жилд 1 удаа Тухайн жилийн БОХТ-ний хэрэгжилтийн тайланг боловсруулж, цахимаар бүрийн 11-р сарын 1-ний дотор хүргүүлнэ. | БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газарт цахимаар илгээсэн. |
| 3 | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны албанд | “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тайлан бэлтгэж хүргүүлэх | БОХТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах | Жилд 1 удаа | БОМТ-ний хэрэгжилтийн тайланг цахимаар илгээсэн. |

**Хавсралт зургууд**




*Агаарын чанарын хэмжилт хийсэн байдал*




*Хөрсний хүнд металлын дээж авсан байршил*



*Үйлдвэрийн талбайд орчны тохижуулалт хийсэн байдал*



*Мод тарьж буй байдал*





*Үйлдвэрийн тоног төхөөрөмж угсралтын ажлын явц болон үйлдвэрийн дотоод зохион байгуулалт*






*Үйлдвэрийн самрын яс түлдэг халаалтын зуухны зохион байгуулалт*



*Намаз /Уусмал/ бэлтгэх хэсэг*




*Химийн бодисын агуулахын тохижилт хийж буй байдал*






*Химийн бодисын агуулахыг тохижуулж бүрэн засвар хийж ашиглалтад оруулсан байдал*

“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

MNAS Accreditation system TL 145 MNS ISO/IEC 17025

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, УЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

**№ 24/08-20**/1

Захиалагч: **“Лагуна Оюу” ХХК**
Дээж авсан цэг**: “Торгон шир бэлтгэл” ХХК, СХД 32-р хороо, Үйлдвэрийн хашаа эмээлт**
Сорьц авсан огноо: **2024 оны 08 сар 12 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **08 сарын 20**

1. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Дээж 1 | 0-10 | 66.7 | 38.6 | 0.0 | 54.7 | 17.8 | 54.7 |
| Зөвшөөрөгдөх, дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

**Харгалзах түвшин* * *Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарн*

*ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр* MNS ISO 11466:2007*)*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ : Б.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 145 УИТ0054

Нарт ШУУН Консалтинг ХХК

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2024 оны 08 сарын 10 өдөр
Шинжилгээ хийсэн: 2024 оны 08 сарын 12 өдөр
Сорьц авсан газрын нэр: Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, Эмээлт

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Торгон Шир Бэлтгэл" ХХК

Солбицлол: X= 47° 54' 8.08" Y= 106° 34' 10.05"

Гүн: м
Ундарга: л/сек

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

| Анион | $1дм^3$ -д байгаа | | | Катион | $1дм^3$ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 408.3 | 11.50 | 45.2 | $Na^++K^+$ | 210.9 | 9.17 | 36.0 |
| $SO_4^{--}$ | 420.0 | 8.75 | 34.4 | $Ca^{++}$ | 174.1 | 8.69 | 34.1 |
| $NO_2^-$ | 0.7 | 0.02 | 0.1 | $Mg^{++}$ | 92.4 | 7.60 | 29.9 |
| $NO_3^-$ | 12.0 | 0.19 | 0.8 | $NH_4^+$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $HCO_3^-$ | 305.0 | 5.00 | 19.6 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| Дүн | 1146.0 | 25.46 | 100.0 | Дүн | 477.4 | 25.46 | 100.0 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 1470.9 мг/ $дм^3$

Анион катионуудын нийлбэр: 1623.4 мг/ $дм^3$

Ерөнхий хатуулаг 16.29 мг-экв/ $дм^3$
pH: 7.43

EC: 1916 µS/cm
TDS: 1149 ppm

Исэлдэх чанар: 2.56 мг/ $дм^3$

**Физик шинж чанар**

Тунгалаг: 30 см
Өнгө: Өнгөгүй
Үнэр: үгүй
Амт: ***
Тунадас: Үгүй

Усны найрлагын томъёо: $M_{1.62}\dfrac{Cl^-45\ SO_4^{2-}34\ HCO_3^-20}{Na^++K^+36\ Ca^{2+}34\ Mg^{2+}30}$

**Дүгнэлт**

*Химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, холимог бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, хлор, кальци, магнийн ионууд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018" стандартад заасанаас их байгаа учир ундаанд хэрэглэхэд тохиромжгүй.*

***Жич:*** *Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээ
Гүйцэтгэсэн: Химич, ЭШДэ: ____________ /Г.Үүрийнтуяа/
Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч ____________ /Д.Гэрэлт-Од/

БАТЛАВ:

СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
..........Б.ЭНХТОГТОХ

2024 оны 07 сарын 31 өдөр

БАТЛАВ:

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ТОХИЖИЛТ ЦЭВЭРЛЭГЭЭ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНӨААТҮГАЗРЫН
ЗАХИРАЛ..................Б.БАТЖАРГАЛ

Дугаар 1341/82

БАТЛАВ:

ААН БАЙГУУЛЛАГА

ЗАХИРАЛ............

Улаанбаатар хот

## ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ХУРААХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

### НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1 Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, төсөвт болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ачих, тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

2.1 Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 , 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн шинэчилсэн найруулга Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3, 41.5, 41.8, 43 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан "Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам", Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01-р тогтоолыг үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

2.2 Энэхүү гэрээг

**НЭГ ТАЛААС**: Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс /цаашид татварын байцаагч гэх / Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх "Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв" ОНӨААТҮГ /цаашид тээвэрлэгч гэх/с
**НӨГӨӨ ТАЛААС**:
Торгон зохиол бэлтгэл /66675522/...........иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага /доогуур зурах/.........................үйл ажиллагааны чиглэлтэй /цаашид үйлчлүүлэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 2024 оны 01 -р сарын 01-ны өдрөөс эхлэн

2024 оны 12 -р сарын 31 өдрийг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

### ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Татварын хууль тогтоомжид заасны дагуу татварын байцаагч нь сар бүрийн 25-ны дотор гэрээнд заасан үнийн дүнгээр хог хаягдлын хураамжийг хураан авах эрхтэй.

4.2 Гэрээнд зааснаар үйлчлүүлэгч нь гэрээний үүргийг биелүүлээгүй болон биелүүлэхээс татгалзсан тохиолдолд татварын алба нь Татварын ерөнхий хуулийн

55 дугаар зүйлээс 73 дугаар зүйлд заасан процесс ажиллагааг хийх эрхтэй.

4.3 Аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тээвэрлэгч байгууллагатай тооцоо нийлж байх үүрэгтэй.

4.4 Татварын байцаагч нь аж ахуй нэгж байгууллага бүрээс хог хаягдлын хураамжийг тогтсон хугацаанд, тогтмол хурааж тээвэрлэгч байгууллагын ачилт хийх боломжийг хангах үүрэгтэй.

4.5 Аж ахуй нэгжээс нэхэмжлэлээр хураасан хог хаягдлын хураамжийн задаргааг тээвэрлэгч байгууллагад дараа сарын 3-ны дотор аж ахуй нэгж, байгууллага гаргаж өгөх.

### ТАВ. ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Тээвэрлэлт хийсэн аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр Татварын хэлтэстэй тооцоо нийлж байх үүрэгтэй.

5.2 Гэрээний үнийн дүн болон ачуулж байгаа хог, тээвэрлэлтийн зардал бодит байдал дээрээ хоорондоо нийцэхгүй тохиолдолд тээвэрлэгч байгууллагаас татварын хэлтэст ИТХ-ийн 10/01 дугаар тогтоолд заасан тарифын дагуу үнийн санал гаргаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

5.3 Үйлчлүүлэгчийн хог хаягдлыг тээвэрлээгүйтэй холбоотой гомдол гаргавал тооцоо нийлж, протокол үйлдэж, тээвэрлэлтийн баримтаар нотлогдоогүй бол хохирлыг тээвэрлэгч байгууллага барагдуулах үүрэгтэй.

5.4 Хог хаягдлын ачилт хийсэн хуудас, нэхэмжлэлийг сар бүрийн 20-ны дотор Татварын хэлтэс өгч, ачилт хийсэн аж ахуй нэгж, иргэн, албан байгууллагын мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хогийг тээвэрлэхгүй.

## ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Өөрийн гаргасан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтсон хогийн цэгт хаях болон овор хэмжээнээс хамаарч хогны захиалгыг урьд өдөр нь тээвэрлэгч байгууллагын 70000818 дугаарын утсанд ажлын цагаар дуудлага өгнө. Гэрээнд заасан тарифийн дагуу тогтмол рейсийн тоогоор тээвэрлүүлэх.

6.2 Татварын байцаагчаас хог хаягдлын хураамж тушаасан баримт, Тээвэрлэгч байгууллагаас хог хаягдлыг ачуулсан баримтыг шаардан авах эрхтэй.

6.3 Захиалгаар болон тогтсон хуваарийн дагуу очсон тээвэрлэгч авто машиныг хоосон буцаасан, халуун үнс нурамтай, цогтой, хөлдүү хог хаягдал зэргээс шалтгаалж хог ачих, тээвэрлэх, нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, тохиолдолд гарсан зардлыг тухайн аж ахуй нэгж байгууллага болон иргэн өөрөө хариуцна.

6.4 Үйлчлүүлэгч нь тогтсон хугацаанд татварын байцаагчид гэрээний дагуу хог хаягдлын хураамжийг төлж байх, Тээвэрлэгч байгууллагад тогтсон хугацаанд, зориулалтын цэгээс, уут саванд хийсэн хог хаягдлыг саадгүй ачуулах үүрэгтэй.

6.5 Ажиллаагүй гэсэн шалтгаанаар хог хаягдлын хураамж төлөөгүй аж ахуй нэгж, иргэн, албан байгууллага тухайн харьяалагдах хорооноос ажиллаагүй гэсэн албан бичиг авч баримтжуулах үүрэгтэй.

6.6 Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-т заасны дагуу шаардлага хангасан зориулалтын хогийн савтай байх үүрэгтэй.

## ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

7.1 Эрх зүйн баримт бичиг болон стандартад өөрчлөлт орсон тухайн цаг үед гэрээ байгуулсан талуудаас санал оруулах нь нээлттэй.

7.2 Үйлчлүүлэгч /1рейсийн/ үйлчилгээний хураамжийг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 14 дугаар тогтоолоор тогтоосон тарифын дагуу /сар бүрийн......................төгрөг/, /улиралд....................төгрөг/, /жилд .....................төгрөг/, /захиалгаар...450,000төгрөг/ төлбөрийг төлнө.

7.3 Татвар төлөгч нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлбөрийн даалгаврыг үүсгэн банкинд төлнө.

7.4 Татварын хэлтэс нь хураасан мөнгөн дүн болон төлбөр өгсөн аж ахуй нэгж, байгууллагын нэрсийг сар бүрийн 05-ны дотор гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах үүрэгтэй.

7.5 Хүний гараар ачих боломжгүй, тусгай техник хэрэгсэл ашиглах шаардлагатай хогийг тээвэрлэгч байгууллагаас тусгай машин, техник гаргаж ачуулсан тохиолдолд гарах зардлыг хариуцсан этгээдээр нэмж гаргуулна.

## НАЙМ. ГЭРЭЭ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргааныг харилцан тохиролцох бөгөөд шийдвэрлэж чадахгүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2 Гэрээний биелэлт дээр татварын хэлтэс, тээвэрлэгч, үйлчлүүлэгч байгууллагууд харилцан хяналт тавьж ажиллана.

8.3 Үйлчлүүлэгч автомашинд сул зогсолт үүсгэж, буцаасан тохиолдолд хураамжийн үнийн 50 хувийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

8.4 Энэхүү гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээг авна.

8.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувиар алданги тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Сонгинохайрхан"Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв ОНӨААТҮГ төлөөлж:
Албан тушаал: Хуулийн зөвлөх
Нэр: М.Цэрэнням
Гарын үсэг /............................/

Аж ахуй нэгж, байгууллагыг төлөөлж:
Албан тушаал.....Гүйцэтгэх захирал
Нэр.....Литанчимэг.............
Гарын үсэг /............................/
Утас.....88810054, 98200369
Хаяг : СХД-ийн 32р хороо Элэгт 413 тоот

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 2240500939459

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 28100186817 / 6266673 |
| Татвар төлөгчийн нэр: | Эко эрин тохижилт |
| Татварын төрөл: | 01030723 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж |
| Харъяалах татварын алба: | Сонгинохайрхан / Дүүргийн төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 400,000.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-05-09 17:26:56 |
| Гүйлгээний утга: | 2240500939459;;6675522;;;88810054;2905152657;ТОРГОН ШИР;Golomtbank-Online;88810054 |
| Татварын данс: | СХД.Хог хаягдлын хураамж - 100200900947 |
| Төлөлтийн хэлбэр: | Голомт банк |

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 2240601330079

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 28100186817 / 6266673 |
| Татвар төлөгчийн нэр: | Эко эрин тохижилт |
| Татварын төрөл: | 01030723 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж |
| Харъяалах татварын алба: | Сонгинохайрхан / Дүүргийн төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 400,000.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-06-13 13:20:13 |
| Гүйлгээний утга: | 2240601330079 91200092138 Эко эрин тохижилт 474053351;ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК;0 |
| Татварын данс: | СХД.Хог хаягдлын хураамж - 100200900947 |
| Төлөлтийн хэлбэр: | MOST |

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 2240705682060

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 63101429837 / 5680174 |
| Татвар төлөгчийн нэр: | Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ |
| Татварын төрөл: | 01030723 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж |
| Харъяалах татварын алба: | Сонгинохайрхан / Дүүргийн төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 450,000.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-07-31 17:01:22 |
| Гүйлгээний утга: | 2240705682060 91200092138 Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ 474053351;ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК;0 |
| Татварын данс: | СХД.Хог хаягдлын хураамж - 100200900947 |
| Төлөлтийн хэлбэр: | MOST |

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 2240700218340

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 91200092138 / 6675522 |
| Татвар төлөгчийн нэр: | Торгон шир бэлтгэл |
| Татварын төрөл: | 01030708 - Ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөр |
| Харъяалах татварын алба: | Сонгинохайрхан / 32-р хороо |
| Төлсөн дүн: | 150,000.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-06-05 13:54:00 |
| Гүйлгээний утга: | I96334 - байцаагч үүсгэв;;99999999 |
| Татварын данс: | СХД.Ус, рашааны төлбөр - 100200900944 |
| Төлөлтийн хэлбэр: | МТА |

**БАТЛАВ: "ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ" ХХК** **БАТЛАВ: "ДОНДОВДАШ" ХХК**

ЗАХИРАЛ.............................Ж.АЛТАНЧИМЭГ ЗАХИРАЛ.............................Б.ГАНСҮХ

УЛААНБААТАР ХОТ
ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ ХХК
гэрээний
6675522 СБТ23018

УЛААНБААТАР ХОТ
ДОНДОВДАШ ХХК
9023040544
6342245 СБТ21832

**ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ**

2023он 10-р сарын 25 өдөр № 009/23 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас РД: 6675522 дугаартай "ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ" ХХК /цаашид Захиалагч тал гэх/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ж.Алтанчимэг
Нөгөө талаас "Дондовдаш ХХК /цаашид Гүйцэтгэгч тал гэх/ түүнийг төлөөлж захирал Б.Гансүх нар нь доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож зөвшөөрснөөр байгуулав.

**Нэг. Нийтлэг заалт**

1.7 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал Захиалагч талын эзэмшилийн "Торгон шир бэлтгэл" ХХК-ийн бохир усыг өөрийн ажиллах хүч, техник тоног төхөөрөмжөө ашиглан тээврлэх, захиалагч тал нь тухайн ажилд нь тохирсон хөлс төлөх болон талуудын эрх үүргийн харилцааг зохицуулахад оршино.
1.8 Энэхүү гэрээний хугацаа 2023 оны 10 сарын 25- ны өдрөөс 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
1.9 Талууд гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээг цуцлах талаар санал гараагүй тохиолдолд гэрээг ижил нөхцөл хугацаатайгаар дахин сунгагдсанд тооцно.

**Хоёр. Төлбөр тооцоо, түүнийг төлөх үндэслэл**

2.5 Хоёр тал харилцан тохиролцсоноор үйлчилгээний ажлын нэг удаагийн тээврлэлтийн үнэ нь дор дурдснаар байх бөгөөд уг үнэд НӨАТ орсон \ороогүй \ болно.
10 тн машин 1 рейс нь 200,000 төгрөг байна.
2.6 Захиалагч талын санал болгосон тонны автомашинаар гүйцэтгэгч тал нь тээврлэлтийг хийх бөгөөд захиалагч тал нь үнийг шилжүүлэхдээ энэхүү гэрээний 2.1 дэх заалтыг удиртгал болгон нэхэмжлэхийн дагуу төлбөрийг ажлын 5 хоногт төлнө.

**Гурав. Захиалагчийн эрх үүрэг**

3.11 Үйлчилгээний дуудлагыг тухайн бохир ус тээврлэлт хийлгэх өдрийн урд өдөр 09.00-18.00 цагийн хооронд үйлчилгээ гүйцэтгэгчид өгсөн байна. Хэрэв тухайн заасан цагт дуудлага өгөөгүй бол дуудлага дараа өдрийн дуудлагад орох.
3.12 Бохир ус сорох явцад хяналт тавьж дутуу сорсон тухай бүр үйлчилгээг гүйцэтгэгчид мэдэгдэж шаардлага тавьж доголдол арилгах хугацааг тогтоон гүйцэтгэгч талын зардлаар дахин гүйцэтгүүлэх.
3.13 Гүйцэтгэгч талтай тохирсоны дагуу аливаа хөнгөлөлтийг нэмэлт нөхцөлд заасны дагуу эдлэх.
3.14 Зайлшгүй шаардлагатай нэмэлт ажил /шугам бөглөрөх, лайдах, дулаалах г.м/ гарвал үйлчилгээг гүйцэтгэгчтэй тухайлан харилцан тохиролцоны дагуу үйлчилгээг хийлгүүлэх.
3.15 Ажлын хөлсийг нэхэмжилсэнээс хойш ажлын өдөрт багтаан төлөхгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0,5%-тай тэнцэх хэмжээний алдангийг захиалагч нь гүйцэтгэгчид төлөх.

**Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх үүрэг**

4.9 Үйлчилгээний ажлыг дуудлагын дагуу, тогтоосон хугацаанд шуурхай ирж, чанартай гүйцэтгэх;
4.10 Захиалагчийн соруулсан бохирын цооногийг судалж үнийн дүнг тогтоох, өөрчлөх талаар санал тавьж тохиролцох;
4.11 Үйлчилгээ гүйцэтгэх явцад захиалагчийн алдаанаас болж / бохирын хоолойн бүрэн бус байдал, ус алдалт, цооног, хөлдөлт г.м / гологдол гарвал өөрсдийн тохирсон өртгөөр нэмэлт үйлчилгээ хийж тухайн рейсэн дээр нэмэлт хөлсийг авах;

4.12 Гэрээнд заасан үүргээ гүйцэтгэгч тал нь бүрэн болон зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд өмнөх сарын үйлчилгээний нийт төлбөрийн 20 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг захиалагчид төлөх;

**Тав. Талуудын хүлээх хариуцлага**

5.9 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол учруулсан бодит хохирлоо буруутай тал нь нөхөн төлөх үүрэгтэй.

5.10 Бодит хохирол гэдэгт үүргийн гүйцэтгэлийг хангахад гарсан зардал, учирсан гэмтэл, алдагдал зэргийг ойлгоно.

5.11 Гүйцэтгэгчийн буруугаас буюу гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, бүрэн дүүрэн биелүүлээгүйгээс Захиалагч төлбөрийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд 3.5 дах заалт хамаарахгүй.

5.12 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас торгууль, алданги төлсөн явдал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

**Зургаа. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл**

6.5 Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, цаг агаарын саатал, зам боогдох, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, г.м/ нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно. Энэ тохиолдолд тухайн хугацаагаар гэрээ сунгагдсанд тооцно.

6.6 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

**Долоо. Бусад зүйл**

7.5 Энэхүү гэрээтэй холбогдож гарсан маргааныг 2 тал аль болох харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд харилцан тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд МУ-ын хууль тогтоомжийн дагуу, харъалах Шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

7.6 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба талуудад хууль зүйн хувьд адил хүчинтэй гэрээний 1 хувь хадгалагдана.

**Найм. Талуудын албан ёсны хаяг**

| Захиалагч | Гүйцэтгэгч |
|---|---|
| Хаяг: | Хаяг: БГД 11-р хороо Хасбаатар гудамж |
| "ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ" ХХК | 41-34 тоот |
| Утас: 88810054, 86129990 | Утас: 89007271 |
| МЭЙЛ: torgonshir.beltgel@gmail.com | Факс: |
| | Захиалга өгөх утас: 89007271 |

**Гэрээ байгуулсан**

| | |
|---|---|
| Захиалагч талыг төлөөлж: | Гүйцэтгэгч талыг төлөөлж: |
| Ерөнхий нягтлан | Нягтлан |
| /Р.Мөнхчимэг/ | /Б.Долгорсүрэн/ |

ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ ХХК
ГЭРЭЭНИЙ

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000271678

2023.04.11
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011850788
/ Хувийн хэргийн дугаар /

8342245
/ Регистрийн дугаар /

Дондовдаш Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2023.04.10 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |
| 49230 | Автомашинаар ачаа тээвэрлэх |

| Хугацаагүй | 1 | 20.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, 3 хороолол, хасбаатар, 41, 34 тоот, Утас1: 89007271, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ Н.ЗОЛЖАРГАЛ
/тамга/ /гарын үсэг/

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар **00542**

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг тус тус үндэслэн.........................................**Улаанбаатар**.................................аймаг/нийслэлийн .............................................................**Баянгол**.......................................... сум /дүүргийн .................................................**"ДОНДОВДАШ" ХХК**.................................................... –д

**9011850788**
*/улсын бүртгэлийн дугаар/*

**8342245**
*/регистрийн дугаа*

....................**Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.14-д заагдсан ........................** Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Зохицуулах Зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн **49** тоот тогтоолыг үндэслэн 3 **/Гурав/** жилийн хугацаагаар олгов.

*Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.*

***Тусгай зөвшөөрөл:***

*Олгосон огноо:* ***2023-05-19*** *Дуусах огноо:* ***2026-05-19***

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** **/Ж.БАТСУУРЬ/**

2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр
Улаанбаатар хот

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

# ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000008342245000240909000001759571
**Борлуулагчийн:**
ТТД: 8342245
НЭР: Дондовдаш
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, хасбаатар, 34 тоот
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-09-09
**Худалдан авагчийн:**
ТТД: 6675522
Нэр: Торгон шир бэлтгэл
Хаяг:
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир усны шугам, бохир усыг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ | 9411000 | ш | 1 | 200,000 | 200,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 200,000 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 0 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 200,000 |

Хүлээн авсан: ...................................................... /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

Хүлээлгэн өгсөн: ................................................ /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

# ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000008342245000240904000001389201
**Борлуулагчийн:**
ТТД: 8342245
НЭР: Дондовдаш
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, хасбаатар, 34 тоот
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-09-04
**Худалдан авагчийн:**
ТТД: 6675522
Нэр: Торгон шир бэлтгэл
Хаяг:
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир усны шугам, бохир усыг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ | 9411000 | ш | 1 | 400,000 | 400,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 400,000 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 0 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 400,000 |

Хүлээн авсан: ...................................................... /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

Хүлээлгэн өгсөн: ................................................. /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

# ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000008342245000240416000001066473
**Борлуулагчийн:**
ТТД: 8342245
НЭР: Дондовдаш
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, хасбаатар, 34 тоот
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-04-16
**Худалдан авагчийн:**
ТТД: 6675522
Нэр: Торгон шир бэлтгэл
Хаяг:
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир усны шугам, бохир усыг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ | 9411000 | ш | 1 | 600,000 | 600,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 600,000 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 0 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 600,000 |

Хүлээн авсан: ........................................................ /......................................./
*(гарын үсэг) (нэр)*

Хүлээлгэн өгсөн: ................................................ /......................................./
*(гарын үсэг) (нэр)*

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

# ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000008342245000240428000001494954
**Борлуулагчийн:**
ТТД: 8342245
НЭР: Дондовдаш
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, хасбаатар, 34 тоот
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-04-28
**Худалдан авагчийн:**
ТТД: 6675522
Нэр: Торгон шир бэлтгэл
Хаяг:
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир усны шугам, бохир усыг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ | 9411000 | ш | 1 | 400,000 | 400,000 |

Бараа, ажил үйлчилгээний үнэ: 400,000

| | |
|---|---|
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 0 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 400,000 |

Хүлээн авсан: ........................................................ /......................................./
(гарын үсэг) (нэр)
Хүлээлгэн өгсөн: ................................................... /......................................./
(гарын үсэг) (нэр)

БАТЛАВ:
"ЭЛЕМЕНТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Б.ЭНХБАДРАЛ/

БАТЛАВ:
"ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Ж.АЛТАНЧИМЭГ/

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ ХБ-24/006

2024 оны 01-р сарын 10-ны өдөр 24/06/03 Улаанбаатар хот

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Нэг талаас "Элемент" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж, Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа нөгөө талаас /цаашид захиалагч гэх/-ыг "Торгон шир бэлтгэл" ХХК-ийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай Р.Мөнхчимэг бид харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, устгахад оршино.
1.2. Захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

**ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ**

2.1. Захиалагч дараах эртэй:
2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,
2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.
2.2. Захиалагч дараах үүрэгтэй:
2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,
2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,
2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,
2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,
2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,
2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,
2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог ачилтанд хяналт тавих тус тус үүрэгтэй.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:

3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,

3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, аюултай тэмдэглэгээтэй байхыг шаардах хаягтүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй

3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, захиалагч талын хог хаягдлыг гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаанд зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,

3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах

3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,

3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

## ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрт тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.

4.2. Захиалагч аюултай хог хаягдлын устгал өгөхөөс өмнө устгалын урьдчилгаа төлбөр **500,000.0 /Таван зуун мянга/** төгрөг гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ. Урьдчилгаа төлбөр нь нийт устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.

4.3. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачил тээвэрлэлт хийх үед болон усгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжлэнэ.

4.4. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар устгалын акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор "Элемент" ХХК-ийн 1715164140 /Голомт банк/ тоот дансанд төлнө.

4.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой обьектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ,

4.6. Төлбөр тооцоог байгууллагын данснаас бусад хувь хүний дансанд шилжүүлсэнээс үүдэх хохиролыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

4.7. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээг 1 жил буюу 2024 оны 01-р сарын 10-ны өдрөөс 2025 оны 01-р сарын 10-ны өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү гэрээний 4.4-т заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.

5.2 Энэхүү гэрээний 4.7-д заасан хугацаанд гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.

5.3 Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх дүрэм журмыг мөрдөөгүйгээс гэрээнд оролцогч талуудад гэм хор учирсан бол буруутай тал нь хариуцлагыг бүрэн хүлээнэ.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.

6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй,эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамааргдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.

7.2. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

8.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

8.2. Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

## ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

9.1. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэлд гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна.

9.2. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

9.2.1. Гэрээний хугацаа дуусаж, гэрээний биелэлтийг дүгнэснээр,

9.2.2. Талууд харилцан тохиролцсоноор,

9.3. Гэрээ дараах үндэслэлээр хугацаанаас өмнө цуцлагдана. Үүнд:

9.3.1. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа (2 ба түүнээс дээш удаа) биелүүлээгүй бөгөөд энэ талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй,

9.3.2. Талууд оролцогч талын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан зэрэг болно.

## АРАВ. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА

10.1. Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

10.2. Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.

10.4. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.

10.5. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

10.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн туршлагатай ажилтан, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй, ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн холбогдох хууль журмын дагуу шударгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй болохыг үүгээр баталж байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Ерөнхий менежер албан тушаалтай

.............................................../Б.Ундармаа/

Утас:88103666

Ерөнхий нягтлан бодогч албан

тушаалтай....................................../А.Энхтуяа /

Утас:86113790

*/Тамга, тэмдэг/*

Харилцах утас: 8610-3790, 9910-7745

РД:2100061

Хаяг: Налайх дүүрэг 3-р хороо, Бүс нуур /12610/

Захиалагчийг төлөөлж:

Ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай

................................................. /Р.Мөнхчимэг/

Утас: 88810054

РД:6675522

Хаяг: СХД 32-р хороо, Эмээлт 413 тоот

Утас: 86129990

Химийн хортой болон аюултай бодисын хаягдал
тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх ХБ-24/006 дугаартай
гэрээний хавсралт №1

Энэхүү гэрээгээр зөвхөн доорх хаягдлыг хүлээн авч хадгалан, устгал хийнэ.

| АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ | | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгж үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Химийн бодисын хоосон шуудай | кг | 1 | 4,500.0 |
| 2 | Тээвэрлэлт /50кг хүртэл хот дотор/ | рейс | 1 | 150,000.0 |

/Дээрхи тээвэрлэлт, устгалын зардал нь НӨАТ ороогүй дүн бөгөөд зардлыг тооцохдоо НӨАТ -ын 10% нэмж нэхэмжилнэ/

**Устгах арга аргачлал:** Дээрхи хог хаягдлыг зориулалтын эргэлтэт системтэй 2ST загварын шатаах зууханд 2 давхар шатаах камер (1-р камер 800$^0$C, 2-р камер 1200$^0$C)-т 99% шатааж устгалд оруулна. Шаталтаас үүссэн үнсний хаягдлыг зориулалтын ландфиллын талбайд булшилж устгана.

Гэрээний үнийн задаргааг гаргасан.
Гүйцэтгэгч талаас:
Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа (гарын үсэг) Б.Ундармаа

МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000272868

2007.01.29
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011082081
/ Хувийн хэргийн дугаар /

2100061
/ Регистрийн дугаар /

Элемент — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 1 | 1996.08.23 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 9609 | Халуун ус |
| 3821 | Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай эрсдэлтэй хог хаягдал устгах үйлдвэр |
| 1030 | Хүнсний ногоо даршлах, хадгалах |
| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |

| Хугацаагүй | 2 | 10,660.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Налайх, 3-р хороо, бүс нуур /12610/, 77 тоот, Утас1: 99193790, Утас2: 99107745, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Т.ЗУЛЗАЯА
/тэмдэг/ /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2023 он 06 сар 22 өдөр

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Зундуй овогтой Баярсайхан-г Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | 2013.05.13 | Г.Өлзийбаяр |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | 2023.06.22 | Т.Зулзаяа |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000272868

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ**

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0000032 Огноо: 2023.09.25

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал Аюултай хог хаягдлийг цуглуулах, тээвэрлэх, устгах (зөвшөөрлийн төрөл) үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 9011082081 улсын бүртгэлийн дугаартай 2100061 регистрийн дугаартай Элемент ХХК -д 2023 оны 09 дугаар сарын 25 -ны өдрөөс 2028 оны 09 дугаар сарын 25 -ны өдөр 5 жилийн хугацаагаар олгов.

**Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар 0000025

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар хот аймаг, хот Налайх сум, дүүргийн 3-р дугаар баг, хорооны бүс нуур /12610/, 77 тоот (гудамж, байшин/хашааны дугаар)

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар аймаг, хот Налайх сум, дүүргийн 3-р дугаар баг, хорооны бүс нуур /12610/, 77 тоот (газрын нэр/гудамжны нэр, дугаар)

**Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.**

**Зөвшөөрөл олгосон:**

| | | |
|---|---|---|
| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | Б.Бат [signature] | Б.БАТ-ЭРДЭНЭ |
| (байгууллагын нэр, албан тушаал) | (гарын үсэг, тамга) | (овог нэр) |

2023 оны 09 сарын 25 өдрийн
0000023 зөвшөөрлийн
1 хавсралт

| № | Тушаалын дугаар | Хугацаа | Олгосон өдөр |
|---|---|---|---|
| 1 | A/464 | 2023.09.25-2028.09.25 | 2023.09.25 |
| 2 | | | |
| 3 | | | |
| 4 | | | |
| 5 | | | |

| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | | Б.БАТ-ЭРДЭНЭ |
|---|---|---|
| (байгууллагын нэр, албан тушаал) | (гарын үсэг, тамга) | (овог нэр) |

**САНАМЖ:**

Тус яамнаас олгосон энэхүү гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, үйл ажиллагаандаа ноцтой алдаа дутагдал гаргасан, худалдан борлуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол хүчингүй болгох үндэслэл болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/21 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

**Дагалдах бичгийн дугаар:**

**1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл**

Бүртгэлийн дугаар: Y

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

**Овог нэр (дармал үсгээр бичих)** Гарын үсэг (тамга) он сар өдөр

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**

**1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар:** ____________

**Тээвэрлэгч аж ахуй нэгжийн нэр: "Элемент" ХХК**

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| № | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал | Савалгаа ны | Савны |  | Хэмжээ | Нэгж (кг, л) | Аюултай хог хаягдлын код | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар | төрөл | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | | | | | | |

**5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

**6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:**

**1/ Овог нэр (дармал үсгээр бичих)** Гарын үсэг (тамга) он сар өдөр

**7. Үл зохицол:**

**8. Аюултай хог хаягдал хүлээн авагчийн мэдээлэл:**

Аж ахуй нэгжийн нэр: **Элемент ХХК** Бүртгэлийн дугаар: 0 0 0 0 1 1

Аюултай хог хаягдал хүлээн авсан:

**Овог нэр (дармал үсгээр бичих)** Гарын үсэг (тамга) он сар өдөр

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

# ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000002100061000240202000001996360
**Борлуулагчийн:**
ТТД: 2100061
НЭР: Элемент
Хаяг: Улаанбаатар, Налайх, 3-р хороо, null
Утас: 86113790
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-01-31
**Худалдан авагчийн:**
ТТД: 6675522
Нэр: Торгон шир бэлтгэл
Хаяг:
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аюултай хог, хаягдал боловсруулах, зайлуулах үйлчилгээ | 5 | ш | 1 | 500,000 | 500,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 454,545.45 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 45,454.55 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 500,000 |

Хүлээн авсан: ...................................................... /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

Хүлээлгэн өгсөн: .................................................. /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ТӨМӨРБААТАР

БАТЛАВ.
"ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.АЛТАНЧИМЭГ

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

202.4 оны 06-р сарын 14-ны өдөр Дугаар 2024-03/309 Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14 дэх заалт, Нийслэлийн Байгаль орчны газрын 2024 оны 2024/62 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нямхүү, Ус ашиглагчийг төлөөлж Улсын бүртгэлийн 9011825574, регистрийн 6675522 дугаартай "Торгон шир бэлтгэл" ХХК-ийн захирал Ж.Алтанчимэг нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр . Гэрээний нөхцөл:

2.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:
Малын арьс нэхийнээс үсийг гэмтээхгүйгээр хуурай технологоор боловсруулах үйлдвэр

2. 2 Ашиглах усны хэмжээ:

-Ундарга нь 1,5 л/с ус авч ашиглах боломжтой. Хоногт дунджаар 15 м$^3$ ус ашигладаг.
1 ажилтан хоногт 180 л ус хэрэглэнэ гэж үзвэл: 44 ажилтан 154 хоногт 1219.68м$^3$
1ш мод услахад 40л хэрэглэнэ, гэж үзвэл 30ш мод услахад 1.2 м$^3$, 20 удаа услахад 24.0 м$^3$ **Нийт 1459.28м$^3$**

2.3. Усны чанар, найрлага:
Шинжилсэн хими болон нянгийн үзүүлэлтүүд нь "Унд ахуйн усны эрүүл ахуйн стандарт MNS:0900:2018"-ын шаардлага хангаж байна.

2.4. Усны эх үүсвэрийн:
Байршил: Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Баруун турууны аманд
Солбицол: 47°54'39 "N, 106°34'1.19"E
Барилга байгууламж: Үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан гаргасан 110 м гүнтэй 1 худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.
Тоног төхөөремж нэр марк: Худагт QJP 2.2 квт 3 тн-ын 220 вт усны насосыг 100 м гүнд суурилуулсан.

2.5. Хаягдал усны хэмжээ, хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга түвшин:
Бетонон доторлогоотой бохирын цооногтой.10м3

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ /кг/:
Улиралд 1215 м3/жил

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Дондог даш ХХК-тай бохир ус татан зайлуулах гэрээ байгуулсан. Хотын бохир усны шугамд нийлүүлдэг.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц бохирдлоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: -

2.9. Усны тоолуурын: Загвар, нэр, дугаар: Aguastar загварын 2.5 м$^3$/ц хэмжих хязгаартай, 20 мм - ийн голчтой №02001284-ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 001 лацаар битүүмжилж, 2024 оны 01 –р сарын 12 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгосон.

Тоолуурын тоо: 1

Тоолуур баталгаажуулалтын гэрчилгээ олгосон байгууллага огноо: Стандартчилал, хэмжил зүйн газар, 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Тоолуурын заалт: Тоолуурын заалт 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар 00003 м$^3$.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2024 оны усны нөөц ашигласны төлбөрийг "Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай", Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 302, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор тоолуурын заалтаар **/1м$^3$ усны төлбөр 94.4/** төлбөр төлнө.

2.10.1 Унд ахуй үйлдвэрлэлд ашигласан **1459.28м$^3$** газрын доорх ус ашигласны төлбөрт нийтдээ **137,756.03** /Нэг зуун гучин долоон мянга долоон зуун тавин зургаан төгрөг гурван мөнгө/ төгрөгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг тоолуурын заалтаар эсхүл ус ашиглах дүгнэлтээр тогтоосон дүнгээр 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор Сонгинохайран дүүргийн Төрийн сангийн 10020090944 тоот дансанд төвлөрүүлж ажиллана.

## Гурав. Талуудын эрх үүрэг.

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

3.3 Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

3.4.Ус ашиглуулагч нь энэхүү гэрээнд заасан арга хэмжээг зохион байгуулахдаа ус ашиглагч талын удирдлагын баг болон ажилтан холбогдох албан тушаалтанд мэдэгдэхгүйгээр хувьд нь хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг хориглоно.

3.5.Хэрэв үүнээс үүдэн талууд болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

3.6. Ус ашиглагч нь ус ашиглуулагч талын удирдлагын баг болон ажилтнаас энэхүү гэрээтэй холбогдуулан хөнгөлөлттэй худалдаа, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг ус ашиглагч талын эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй.

## Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаархи дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Усан орчин ашиглуулагчийг төлөөлж:

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
Дарга Ж.Нямхүү

Байгаль орчин, ногоон байгууламж
хариуцсан мэргэжилтэн
С.Сүхцоож

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн
27 дугаар хороо

Харилцах утас: 70173213

Ус ашиглагчийг төлөөлж:

"Торгон шир бэлтгэл" ХХК-ийн
захирал
Ж.Алтанчимэг

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн
32 дугаар хороо

Харилцах утас:94800005, 98200369